

**МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЦОГЦ
БОДЛОГЫГ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
А.Тлейхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2014 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлого нь хүн ам зүйн шилжилтийн цонх үеийг улс орны хөгжил, хүн амын өсөлтийг хангахад үр дүнтэй ашиглах, хөгжлийн чиг хандлагыг хүн ам зүйн шилжилт, насны бүтцийн өөрчлөлт, хүн амын хэтийн тооцоотой уялдуулах, насжилтад бэлтгэх, хүн амын эрүүл, аюулгүй таатай амьдрах орчныг бүрдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэгджээ.

Энэхүү бодлогын хүрээнд эрүүл, чанартай төрөлтийг дэмжих таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалснаар хүн амын өсөлтийг тогтвортжуулах, хүүхэд, залуучуудын боловсрол, соёлын хэрэгцээг ханган хөгжүүлснээр бүтээлч, чадамжтай хүний нөөцийг тогтмол нэмэгдүүлэх, хөдөлмөрийн насны хүн амд хөдөлмөр эрхэлж, ажилтай орлоготой болох нөхцөлийг бүрдүүлэх, хүн амыг эрүүл насжилтад бэлтгэх, ирээдүйн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн үйлчилгээнд шаардлагатай хуримтлалыг бий болгох, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн болно.

Цогц бодлого батлагдсанаар хүн амын тогтвортой өсөлтийг хангах эрх зүйн таатай орчин бүрдэж, хүн амын хөгжлийн чиглэлийн бодлого, төлөвлөлтийн уялдаа холбоо сайжрах, хүн ам зүйн цонх үеийг үр дүнтэй ашиглаж, хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангах, ажилгүйдлийг бууруулах, хүн амд дундаж орлоготой иргэдийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих орчин бүрдэнэ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улаанбаатар хотын захын хороололд хүн хөгжих орчныг бүрдүүлэх, төрөөс үзүүлж буй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад онцгойлон анхаарах, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ энэхүү үндэсний хэмжээний цогц бодлогыг ганц яам дангаар хариуцан хэрэгжүүлэх нь учир дутагдалтай, бодлогод бусад салбар яамдуудын бодлого, үйл ажиллагааг тодорхой тусгаж өгөх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх, тэднийг татан оролцуулах, эрүүл, чанартай төрөлтийг дэмжих, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, дундаас дээш орлоготой иргэдийн тоог

нэмэгдүүлэх, олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаанд тулгуурлах биш төр өөрөө төрөх эмнэлгүүдийн ачааллыг багасгах, хөрөнгө санхүүжилтийн асуудлыг улсын төсөвт суулгах, Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан хүн амын цонх үеийг зохицтойгоор ашиглах, хүн амын эрүүл, чанартай төрөлтийг нэмэгдүүлэх, хүн ам зүйн цонх үеийн дараах үеийн алхмуудыг тооцоолох, бусад салбар яамдын бодлогын уялдаа холбоог сайжруулах, дэлхийн улс орнууд хөгжих тусам хүн амын өсөлт буурах хандлагатай байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан төрөөс хүн амд нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ үзүүлэхээс гадна хамгийн түрүүнд бид хүнээ хөгжүүлэх хэрэгтэй бөгөөд тэднийг зах зээлд амьдрах чадвартай болгох, өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хүний амьдрах ухаан, ухамсар, нийгмийн чиг хандлагыг өөрчлөх, оюун санааг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрүүдийг явуулах зэрэг саналуудыг тус тус гаргасан болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАИНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ